

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 оны 02 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс 2025 оны 01 дүгээр сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тусгагдсан “Визийн зөрчилтэй гадаад иргэдийн тоог бууруулж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд 1 арга хэмжээг хэрэгжүүлснийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дараах байдлаар үнэлэв. Үүнд:

Арга хэмжээ: Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.

Хэрэгжилт: “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр гадаадын иргэний визийн зөвшөөрөл, виз, оршин суухтай холбоотой мэдээллийг бүртгэх, хяналт тавих, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай хангах боломжийг бүрдүүлсэн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн мэдээлэлд бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна.

Гадаадын иргэн, түүний уригчийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор виз болон оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа иргэдийн мэдээллийг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-аас уригч байгууллага, гадаадын иргэний бүртгэлтэй утсанд цахим хэлбэрээр өгөх, хугацаа хэтэрсэн бол гадаадын иргэний хяналтын улсын байцаагч хуульд зааснаар зөрчил шийдвэрлүүлэх талаар уригч, гадаадын иргэнд мэдэгдэх, гадаадын иргэн улсын хилээр нэвтэрснээс хойш 48 цагийн дотор бүртгүүлэх, хаяг, байршлаа өөрчлөх бүрд 48 цагийн дотор бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

2024 онд төлөвлөгөөт 42, төлөвлөгөөт бус 386 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил гаргасан нийт 11067 гадаадын иргэн (хувь хүнээр зөрчил гаргасан 2502, уригч иргэнээр зөрчил гаргасан 38, уригч хуулийн этгээдээр зөрчил гаргасан 8527)-д торгох шийтгэл ногдуулан, 998 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргалаа.

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нийт 636 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан тайлант хугацаанд визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, оршин суух

зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, гадаадын иргэний хаягийн бүртгэл, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлтэй холбоотой нийт 47174 хүсэлтийг хүлээн авч, тус тус хянан шийдвэрлэлээ.

Системийн санхүүжилтийг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлэсэн бөгөөд 2024 онд хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно. (90 хувь)

Энэхүү арга хэмжээ нь тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн гарч эхэлж байгаа тул 01 дүгээр сард хэрэгжилт 90 хувийн биелэлттэй үнэлэгдлээ.

Дээрх арга хэмжээний хүрээнд хэрэгжилт, үр дүнг бууруулахгүйгээр бүрэн хангаж, хяналтыг сайжруулахад анхаарч, бүртгэлийн систем дэх хөгжүүлэлтийг тогтмол хийж, гадаадын иргэний бүртгэлийг тогтмолжуулах шаардлагатай.

--oo0oo--